



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 3

Угшанбаатар хот

Нэгдсэн удирдамж батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27<sup>1</sup> дүгээр зүйлийн 27<sup>1</sup>.1.1, 27<sup>1</sup>.1.4, 28 дугаар зүйлийн 28.1.5, Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 10 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Иргэд, олон нийтийн болон орчны аюулгүй байдлыг хангуулах, аюул, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг арилгах, таслан зогсоох, бууруулах үзлэг, хяналт-шалгалтыг зохион байгуулах нэгдсэн удирдамж-ийг хавсралтаар баталсугай.

2.Удирдамжийг хэрэгжүүлэх нарийвчилсан арга хэмжээний төлөвлөгөөг баталж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн болон бүх шатны Онцгой комиссын дарга нарт үүрэг болгосугай.

3.Удирдамжийн хэрэгжилтийг хангуулж, үр дүнг нэгтгэн танилцуулахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга (хошууч генерал Г.Ариунбуян)-д үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга (Б.Мөнх-Оргил)-д даалгасугай.

ДАРГА



Н.НОМТОЙБАЯР

**ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН БОЛОН ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГУУЛАХ,  
АЮУЛ ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ АРИЛГАХ, ТАСЛАН  
ЗОГСООХ, БУУРУУЛАХ, ҮЗЛЭГ, ХЯНАЛТ- ШАЛГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
НЭГДСЭН УДИРДАМЖ**

**Нэг. Үндэслэл**

1.1.Энэхүү удирдамжийг хэрэгжүүлэхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 474 дүгээр тогтоолоор батлагдсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам”, Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 10 дугаар албан даалгавар болон холбогдох бусад дүрэм, журам, норм, стандартыг мөрдлөг болгоно.

**Хоёр. Зорилго**

2.1.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн түвшинд аливаа болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг арилгах, таслан зогсоох, бууруулах, хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангуулах, Монгол хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчныг хамгаалах, аюулгүй амьдрах, ажиллах ээлтэй орчныг бүрдүүлэхэд нэгдсэн удирдамжийн зорилго оршино.

**Гурав. Хамрах хүрээ, хугацаа**

3.1.Яам, агентлагууд, аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой комисс нь энэхүү үзлэг, хяналт-шалгалтыг эрхлэх асуудлын хүрээнд нэгтгэн зохион байгуулна.

3.2.Үзлэг, хяналт-шалгалтад засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийг хамруулна.

3.3.Нэгдсэн удирдамжийг 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 07 дугаар сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд хэрэгжүүлж, тайлагнана.

**Дөрөв. Авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

4.1. Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга (Салбарын улсын ерөнхий байцаагч)-ын удирдамжаар салбарын хэмжээнд, бүх шатны Онцгой комиссын хурлын шийдвэрээр нэгдсэн үзлэг, хяналт-шалгалтыг засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулна.

4.2.Яам, агентлаг болон бүх шатны Онцгой комиссын түвшинд үзлэг, хяналт-шалгалтын нэгдсэн удирдамжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангуулж ажиллана.

4.3.Үзлэг, хяналт-шалгалтын явцад хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох аюул, эрсдэл нь зохих ёсоор нотлогдсон, аюул, осол гарч болох тохиолдолд холбогдох ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа, нутаг дэвсгэрийг бүхэлд нь

буюу хэсэгчлэн тухайн зөрчлийг арилгах хүртэл хугацаанд хаах, түр зогсоох арга хэмжээг тухай бүр шуурхай авч хэрэгжүүлж, иргэд, олон нийтэд сэрэмжлүүлэг, мэдээллийг тухай бүрт хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүргэж ажиллана.

#### Тав. Зардал

5.1. Үзлэг, хяналт-шалгалтыг зохион байгуулахтай холбогдон гарах зардлыг тухайн яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой комисс, хуулийн этгээд хариуцана.

#### Зургаа. Тайлагнах

6.1. Энэхүү нэгдсэн удирдамжийн хэрэгжилтийн тайланг 2026 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн дотор Улсын онцгой комиссын Ажлын албанд албан бичгээр болон цахим хаяг (uok@nema.gov.mn)-аар ирүүлнэ.

6.2. Тайланг нэгтгэн, үр дүнг Улсын онцгой комисст 2026 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор танилцуулна.

---oOo---